ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Бага тойруу-3,
Ц.Жигжиджавын гудамж-7/1,Хангарди ордон
Утас: 31-54-30
http://www.erc.mn

2019.12.02 № 049

танай ______________-ны №______________-т

ИЛЧ ОРД ОНӨААТҮГ-Т

Танай эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифын тогтоол нь Захиргааны хэм хэмжээний Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн тул 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн тус тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

Жич: Тогтоолын хуулбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 3... хуудастай.

УЛААНБААТАР
НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ
ТБАГУТҮГ
1116115514 ≐ 6033334

НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\Н33-2019\Явуулсан бичиг\A5.docx

2150300038

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2019.11.25 № 1-1/5296
танай 2019.11.21-ны № 046-т

НИЙСЛЭЛИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Т.ГАНТӨМӨР ТАНАА

Улсын нэгдсэн бүртгэлд
бүртгэсэн тухай

Танайхаас ирүүлсэн дор дурдсан тогтоолуудыг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэснийг мэдэгдье. Үүнд:

1.Нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2019 оны "Тариф батлах тухай" 32 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4534 дугаарт;

2.Нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2019 оны "Тариф батлах тухай" 33 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4535 дугаарт.

Ц.НЯМДОРЖ

1118387523 ШТТ6740 9131817

Doc.said a4.2019

151602540

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 11... сарын 28-ны өдрийн 4532 дугаарт бүртгэв.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 11 сарын 13 өдөр | Дугаар 32 | Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 231 дүгээр тогтоолоор баталсан " Цахилгаан, дулааны үнэ тарифыг тогтоох аргачлал", Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн зохицуулах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Нийслэлийн Багахангай дүүргийн Илч Орд ОНӨААТҮГ-ын эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор батлсугай.

2. Батлагдсан тарифыг төсөвт байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны айл өрх Захиргааны хэм хэмжээний Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд"-д нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн зохицуулах зөвлөлийн "Үнэ тарифт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2012 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоосон тарифыг мөрдүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Илч Орд /Д.Гантулга/-т, зохицуулах зөвлөлийн гишүүн Б.Лхагвадуламд тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн Б.Лхагвадуламд даалгасугай.

ДАРГА Т.ГАНТӨМӨР

ГИШҮҮН Б.ЛХАГВАДУЛАМ

ГИШҮҮН М.ЭНХЖАРГАЛ

··2150300071

*Нийслэлийн зохицуулах зөвлөлийн 2019 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн 42 дугаар тогтоолын хавсралт*

## ИЛЧ ОРД ОНӨААТҮГ-ЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

| № | Хэрэглэгчийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /НӨАТ-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагын халаалт | Төг/м³ | 1,200.0 |
| | | Төг/ГДж | 21,718.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт | Төг/м³ | 1,200.0 |
| | | Төг/ГДж | 21,718.0 |
| 3 | Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан | Төг/хүн | 5,040.0 |
| | | Төг/м³ | 6,500.0 |

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

| № | Хэрэглэгчийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /НӨАТ-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Орон сууцны халаалт (оюутны байр, подвол, "00"-ын өрөөний халаалт хамаарна) | Төг/м² | 460.0 |
| | | Төг/ГДж | 3,078.8 |
| 2 | Айл өрхийн хэрэгцээний халуун ус халаасан дулаан | Төг/м2 | 1,800.0 |

--оОо--